

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨСВИЙН БОЛОН ХУУЛЬ
ЗҮЙН БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТӨСВИЙН БОЛОН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7 - 22

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан холбогдох хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болсонд тооцох асуудал 8 - 12
- “Хууль, тогтоолыг хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл 12 - 22

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн болон Хууль зүйн байнгын хороодын 11 дүгээр сарын 29-ний өдөр
/Баасан гараг/-ийн хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хамтарсан хуралдаанд ирвэл зохих нийт 44 гишүүнээс 24 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 44 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Р.Батболд, Х.Баасанжаргал, Ж.Ганбаатар, Г.Дамдинням, Д.Пүрэвдаваа, Б.Пүрэвдорж, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Б.Энхбаяр;

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Н.Алтанхуяг, Х.Баттулга, Б.Батцэцэг, Л.Мөнхбаатар, С.Одонтуяа;

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан холбогдох хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болсонд тооцох асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Х.Ганхуяг, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.8 дахь заалтын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан холбогдох хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болсонд тооцох санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	17
Татгалзсан:	9
Бүгд:	26

65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 7
Бүгд: 26
73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хүчингүй болсонд тооцох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 7
Бүгд: 26
73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Гаалийн тариф гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хүчингүй болсонд тооцох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 10
Бүгд: 26
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийг хүчингүйд тооцох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 6
Бүгд: 27
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 6
Бүгд: 27
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 39 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 6
Бүгд: 27
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 49 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 8
Бүгд: 27
70.4 хувийн саналаар дэмжигдлээ.

9.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 41 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 8
Бүгд: 27
70.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар дээрх хууль, тогтоолын төслүүдийн талаар санал гараагүй тул төслүүдийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх гэсэн горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 9
Бүгд: 27
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 70.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Хууль, тогтоолыг хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн “Хууль, тогтоолыг хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Ганхуяг, Б.Жавхлан, Х.Тэмүүжин, Д.Ганбат, Б.Мөнхсоёл нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэсэн горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 12

Бүгд: 29

58.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 62.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: “Хууль, тогтоолыг хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 11
Бүгд: 29
62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Л.Соронзонболд нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хамтарсан хуралдаан 47 минут үргэлжилж, ирвэл зохих нийт 44 гишүүнээс 28 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 13 цаг 31 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр, Баасан гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
12 цаг 44 минут

ТӨСВИЙН БОЛОН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд ирэх ёстой 44-өөс 24 гишүүн ирж, ирц 54.5 хувьтай байна.

Хуралдааны ирц хангалттай байгаа учраас хуралдаанаа эхэлье.

Би ирсэн гишүүдийг танилцуулна.

Э.Бат-Амгалан гишүүн, Ж.Баясгалан гишүүн, Г.Ганбаатар гишүүн, Ц.Даваасүрэн гишүүн, П.Мөнхтулга гишүүн, Ц.Сандаг-Очир гишүүн, Г.Тэмүүлэн гишүүн, Д.Цогтбаатар гишүүн, Д.Батбаяр гишүүн, Х.Болормаа гишүүн, П.Ганзориг гишүүн, З.Мэндсайхан гишүүн, М.Нарантуяа-Нара гишүүн, Л.Соронзонболд гишүүн, Б.Түвшин гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, Ж.Батжаргал гишүүн, Х.Булгантуяа гишүүн, Х.Ганхуяг гишүүн, Б.Мөнхсоёл гишүүн, У.Отгонбаяр гишүүн, Х.Тэмүүжин гишүүн, Д.Цогтбаатар гишүүн, С.Эрдэнэболд гишүүн нар хуралдаанд ирж бүртгүүлсэн байна.

Хуралдааны ирц 54.5 хувьтай байгаа учраас хуралдаанаа нээснийг мэдэгдье. /алх цохив/

Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг би Та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 90.8-д заасны дагуу 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр баталсан 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль, тогтоолуудыг хүчингүй болгох асуудал.

Хоёрдугаарт, “Хууль хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль, тогтоолын төслүүдийг хүчингүй болгох тухай асуудал

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад үг хэлж, асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Х.Ганхуяг гишүүн байгаа юм уу? Г.Ганбаатар гишүүнээр тасалъя. М.Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууя.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд.

Сая даргын хэлсэн юун дээр тодруулах зүйл байна л даа.

2025 оны төсвийн тухай хууль дагалдаж орж ирсэн хууль тогтоомжид тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулаад хууль хүчингүй болсон гээд та хэллээ л дээ.

Энэ батлагдсан хуулийг хориг тавьсныг хүлээж авсан нь энэ хууль өөрөө бүхэлдээ хүчингүй болчхож байгаа асуудал юм уу? Энэ дээр нэг тодруулга авчихъя. Даргаас.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан Дэгийн тухай хуулийн 90.8-д хоригийг шаардлагатай гэж үзвэл хүчингүй болгох. Мөн шаардлагатай гэж үзвэл зохих нэмэлт, өөрчлөлт оруулах хууль, тогтоолуудын төслийг хэлэлцэх гэсэн ийм хоёр арга зам байгаа.

Энэ удаа бид хүчингүй болгох гэдэг асуудлыг хэлэлцэж байгаа юм.

Х.Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Ер нь яах вэ, энэ чинь бид 126 болоод, тэгээд цаашдаа байнгын олон намын тогтолцоотой хамтарсан эвслийн Засгийн газартай явдаг болно гэсэн үг.

Тэгээд Ерөнхийлөгч нь аль намаас сонгогдох юм. Ирээдүйг би хэлж мэдэхгүй байна.

Тэгээд саяын болсон үйл явдлыг харахаар ер нь цаашдаа янз янзын байдлаар тоглолт хийдэг болох эрсдэл харагдаж байгаа юм.

Ингээд буцаасан нь зөв. Энэ дээр яах вэ би хоёр Байнгын хорооны дарга болон Их Хурлын удирдлагад юу гэж хэлэх гээд байна гэхээр ямар нэгэн байдлаар хариуцлага тооцдог асуудлыг бид заавал ч үгүй хөндөх ёстой.

Ажлын хэсгийн хүрээнд байх юм уу, Байнгын хорооны хүрээнд байх юм уу, Засгийн газрын түвшинд байх юм уу.

Яагаад гэхээр энэ чинь цаашдаа ажлын хэсэгт нь орж ажилласан хүмүүс нь гарч ирээд улс төр хийгээд, тэгээд дараа нь дараагийн ажлын хэсэгт нь орж ажиллана гэвэл энэ ерөөсөө логикийн алдаа болно шүү.

Дараа нь энэ чинь дахиад л ийм асуудал үүснэ л гэсэн үг. Ийм асуудал үргэлжилнэ л гэсэн үг.

Ажлын хэсэгт орж ажилласан хүмүүсийг дараагийн ажлын хэсэгт оруулахгүй байх талаар би хоёр Байнгын хорооны дарга болон Их Хурлын даргаас тусгайлан хүсмээр байна.

Хэрвээ тэр хүмүүс орж ажиллах гэж байгаа бол бид, би тэр тусмаа орж ажиллахгүй гэдгийг энэ ташрамд Та бүхэнд хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Санал байна.

Ер нь яах вэ зүгээр ажлын хэсэгт орж ажиллачхаад, тэгээд дараа нь мэдэгдэл хийсэн талаар л ярьж байх шиг байна л даа. Тийм ээ.

Г.Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Энэ Монгол Улсын Ерөнхийлөгч 2025 оны улсын төсвийн дээр хориг тавьсантай холбогдуулаад 11 сарын 22-нд Ардчилсан намын бүлэг бас энэ асуудлыг дэмжих эсэхээ хэлэлцсэн юм.

Тэгээд тэр үед манай бүлгээс хийж байсан мэдээлэл дээр өмнө нь бүхэлд нь хориг тавьсан тохиолдол 3 удаа, мөн хэсэгчилсэн хориг тавьсан нь 6 удаа болж байсан гэж.

Түрүүн чуулган дээр Д.Цогтбаатар гишүүн бид хориг тавьж байсан. Урьд нь хүлээж авч байсан туршлага бага учир нэг удаагийн хууль гаргаж байгаа юм гэж.

Тэгээд манай бүлэг дээр өгсөн мэдээлэл ташаа байна уу, эсвэл ер нь бүхэлд нь хориг тавьж байсан асуудал, хэсэгчилсэн хориг тавьж байсан асуудал.

Мэдээж Улсын Их Хурлын шинэ бүрэн эрх хэрэгжиж байгаа Улсын Их Хурал, дээрээс нь Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар арай өөр эрх зүйн орчин үйлчилж байна.

Тэгээд эндээсээ одоо бид ийм байдалд байгаагаа үүнийгээ өнгөрсөн байсан туршлагаасаа авах кэйс байхгүй юм уу гэсэн ийм л асуулт байна. Тийм.

3 удаа бүхэлд нь, 6 удаа хэсэгчилсэн.

Ц.Даваасүрэн: Тийм. Нэг л удаа хүлээж авсан юм байна лээ. Г.Ганбаатар гишүүн ээ.

Тэгээд нэг удаа хүлээж авахдаа буцаасан юм байна лээ. Хэсэгчилсэн хориг байсан. Тэгээд буцаасан.

Дэгийн тухай хуулийн 90.8-д хэрвээ хоригийг хэсэгчлэн буюу бүхэлд нь хүлээж авсан бол тэр хууль, тогтоолын төслийг хэсэгчлэн хүчингүй болгох, бүхэлд нь хүчингүй болгох гэсэн нэг асуудал байгаа юм.

Эсвэл шаардлагатай гэж үзвэл мөн нөгөө хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулаад хууль, тогтоолын төслийг хэлэлцээд үргэлжлүүлээд явж болно гэсэн ийм хоёр сонголттой. Хоригийг хүлээж авсан тохиолдолд.

Тэгээд энэ удаа бид ер нь бүхэлд нь хориг тавьчихсан учраас хоригийг хүлээж аваад хууль, тогтоолыг бүхэлд нь буцаая, хүчингүй болгоё гэж байгаа шүү.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Дэгийн тухай хуулийн 90.8-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан бол хууль, тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгох гэж заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай санал хураалт явуулна.

Эхний санал.

1.Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 26 гишүүн оролцож, 17 гишүүн дэмжиж, 65.4 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Ж.Батжаргал гишүүнийг дэмжсэнээр протокол тэмдэглэе.

2.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

26 гишүүн санал хураалтад оролцож, 19 гишүүн дэмжиж, 73.1 хувиар санал дэмжигдсэн байна.

3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хүчингүй болсонд тооцох гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

26 гишүүн санал хураалтад оролцож, 19 гишүүн дэмжиж, 73.1 хувиар санал дэмжигдсэн байна.

4.Гаалийн тариф гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хүчингүй болсонд тооцох гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 26 гишүүн оролцож, 16 гишүүн дэмжиж 61.5 хувиар уг санал дэмжигдсэн байна.

5.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийг хүчингүйд тооцох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

27 гишүүн санал хураалтад оролцож, 21 гишүүн дэмжиж, уг санал 77.8 хувиар дэм дэмжигдсэн байна.

6.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 27 гишүүн оролцож, 21 гишүүн дэмжиж, 77.8 хувиар уг санал дэмжигдсэн байна.

7.“Засгийн газар чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 39 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцох гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 27 гишүүн оролцож, 21 гишүүн дэмжиж, уг санал 77.8 хувиар дэмжигдсэн байна.

8.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 49 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/ 40 дүгээр тогтоол шүү.

Санал хураалтад 27 гишүүн оролцож, 19 гишүүн дэмжиж, 70.4 хувиар уг санал дэмжигдсэн байна.

9.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 41 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 27 гишүүн оролцож, 19 гишүүн дэмжиж, 70.4 хувиар уг санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар гишүүний горимын саналыг сонсьё.

Д.Цогтбаатар: Ингээд сая энэ хуулиуд хүчингүй болж байгаатай холбогдуулаад нэг горимын санал гаргах гэж байна.

Тэр нь дээрх хууль, тогтоолын төслүүдийн талаар санал гараагүй тул хууль, тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаж байна. Үүгээр санал хураалгаж өгөөч ээ.

Ц.Даваасүрэн: Д.Цогтбаатар гишүүний гаргасан горимын саналын дагуу анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 27 гишүүн оролцож, 18 гишүүн дэмжиж, 66.7 хувиар уг горимын санал дэмжигдсэн байна.

Ингээд анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын санал дэмжигдлээ.

Д.Батлут гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглэгдье.

Хамтарсан хуралдаанаас гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Да.Цогтбаатар гишүүн танилцуулчих уу?

Хоёр. “Хууль, тогтоолыг хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хоёр дахь асуудалдаа оръё.

“Хууль хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Би тогтоолын төслийг Та бүхэнд танилцуулъя.

“Хууль хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан баталсан хууль, тогтоолын төсөлд Монгол Улсын Ерөнхийлөгч бүхэлд нь тавьсан хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн авч тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны.

Хугацааг нь хэдүүлээ ярья. 2024 оны хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Л.Оюун-Эрдэнэд даалгасугай.

2. Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоол байгаа юм.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Нэрээ өгье.

Ж.Батжаргал гишүүнээр тасалъя. Д.Батлут гишүүн. Ж.Батжаргал гишүүн. Ирцээрээ юм байна. Ж.Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тэгэхээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоолд тодорхой зүйлсүүд орох уу? Нэгэнт бид хэд сая одоо ингээд хуулиудаа бүгдийг нь хүчингүй болгочихлоо.

Тэгэхээр зэрэг яах аргагүй өнөө төсвийн хуулийг чинь дагаж мөрдөх журмын хуулийг одоо ярихгүй бол бүр яг болохгүй болчхож байгаа юм.

Нэгдүгээрт, Засгийн газар төсөв өргөн барьдаг бас цагалбартай.

Тэгэхээр хориг хүлээн авсантай холбогдуулаад бас энэ удаа тэр тогтоолоор заасан хугацаагаараа байхаар Журмын хуульдаа нэгдүгээрт оруулж өгч байж эрх зүйн хоорондын зөрчилгүй болох болов уу гэж нэг ийм санаа байгаад байх юм.

Хоёр дахь зүйл нь, тэр орон нутгийн төсвүүдийг боловсруулж, өргөн мэдүүлж батлах цаглаврыг одоо ёстой зааж өгөхгүй бол болохгүй болчхоод байгаа юм.

Энэ зүйлийг Засгийн газарт яг энэ юугаар нь чиглэл өгсөн нь дээр болов уу л гэж санаад байх юм. Би.

Боловсруулж оруулж ир. Тэр Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль дээр ийм юмыг оруулж ир гэдэг байдлаар нь оруулбал яасан юм гэсэн санаа байна.

Ц.Даваасүрэн: Тийм. Ж.Батжаргал гишүүний хэлээд байгаа яг хөндөгдөх асуудал мөн байгаа юм.

Мөн энэ дээр нэмэгдээд одоо аудитын дүгнэлт яах вэ гэдэг асуудлууд бас гарч ирж байгаа.

Бид заавал аудитын дүгнэлттэй одоогийн өргөн мэдүүлснийг хэлэлцэх шаардлагатай юу гэдэг асуудал энэ тэр.

Энэ асуудлуудыг ер нь протоколд тэмдэглээд Их Хурлын нөгөө Дэгийн байнгын хороо, холбогдох Байнгын хороо, тэгээд манай Тамгын газрынхан анхаараад энэ дээр ойрын хугацаанд холбогдох хуулийн төслүүдийг ер нь боловсруулж хэлэлцэх нь зүйтэй гэж бодож байна.

Засгийн газраас гадна Их Хурал дээр шийдэх юмнууд гарч ирнэ. Дэгийн тухай хууль, Төсвийн тухай хуультай холбогдуулаад бас авах арга хэмжээнүүд бол гарч ирж байгаа юм.

Х.Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Ерөнхийлөгчийн хоригтой холбоотойгоор бид 14 хоногийн хугацаанд асуудлыг шийдэж батлуулсан байх ёстой гэсэн нэг хугацаа яваад байгаа юм. Тэр нь одоо 12 сарын 06-нд гээд дуусаж байна уу? Тийм үү?

Би буруу ойлгоод байгаа юм байна.

Тэгэхдээ бид энэ дээр хугацаануудаа ер нь хатуу зоож өгөхгүй бол одоо өмнөх бид нөгөө Төсвийн тухай хуулийн олон нийтийн хэлэлцүүлэг, бүгдийг нь зохион байгуулах боломжгүй болно гэсэн үг. Энэ чинь хугацаа алдах боломжгүй болно гэсэн үг.

Тэгэхээр зарим нэг асуудлуудыг нь бид жоохон шуурхайлах, асуудлыг энэ тогтоол дээр оруулж өгөхгүй бол болохгүй.

Дээрээс нь нөгөө орон нутгийн төсвийн сая Ж.Батжаргал гишүүний ярьж байгаа тэр цаглавартай холбоотой. Нөгөө хууль маань угаасаа төсвийн хууль батлагдаагүйгээс болоод хууль зогсож байгаа л гэсэн үг. Тийм.

Тэгэхээр тэр хуулийн үйлчлэл зогсож байгаатай холбоотойгоор нь авах арга арга хэмжээнийхээ юугаа бид тогтоолын төсөл дээр оруулж өгөхгүй бол баахан институт хоорондын зөрчилдөөн үүсэх вий дээ. Уг нь яг тэр төсөв баталдгийг

өглөө уг нь Байнгын хорооны даргад би санал гаргасан шүү дээ. Цөмөөрөө үүнийг буцаачихсан нь зөв байна шүү. Яг энэ асуудал бид өнөөдөр ингээд л үүсэх нь байна гээд л ярьж байсан.

Тэгээд явсаар байгаад л тодотгоно гээд л явчихсан шүү дээ. Цөмөөрөө. Тийм ээ.

Тэгээд энэ дээр Сангийн сайдын байр суурийг авчихсан нь зөв байх. Ер нь.

Ц.Даваасүрэн: Б.Жавхлан сайд энэ дээр хариулт өгчхөөч.

Би ингэж бодоод байна. Ирэх гурав дахийн хуралдаанаар яагаад л та нар дөрөв дэхэд өргөчихвөл яаж байна. 5 шүү дээ. 5-ны дотор. Бас болно.

Б.Жавхлан: Энд улам л ойлгомжгүй байдал руу л орж байгаа юм даа.

Одоо Засгийн газар хугацаандаа 9 сарын 01-нд хуулиа өргөн барьсан. Үүргээ биелүүлсэн. 9 сар бүтэн, 10 сар бүтэн, 11 сарын 08 хүртэл. Энэ чинь хэд хоног байна. Бараг 70-аад хоног Улсын Их Хурал дээр хэлэлцээд хуулиа баталсан.

Ингээд л Улсын Их Хурлын шийдвэр дээр Ерөнхийлөгч хориг тавьсан байгаа. Одоо ингээд энэ дэгээ хүчингүй болгоод. Энэ дэг ч одоо бүр ингээд байхгүй болж байгаа гэж ойлголоо. Тийм ээ.

Тэгээд хуулиа хүчингүй болгочихоор одоо тэгээд юуг үндэслэж Засгийн газар буцааж өргөн барих вэ. 9 сарын 01-нд хууль өргөн барих дэгтэй. Эсвэл тодотгол хэлэлцэх дэгтэй. Тодотгол өргөн барих.

Хууль шинээр дахиж өргөн барих ийм дэг байхгүй.

Уг нь миний бодлоор саяын өнөөдөр хэлэлцэж байсан дэгээ батлаад явчихвал уг нь аль аль талдаа амар байсан юм даа.

Тэр дээр чинь тэр 2.1 заалт гээд орчихсон байна лээ шүү дээ. Засгийн газрын саналыг үндэслэж гээд. Бүр үндэслэж гэхихсэн байна лээ шүү дээ.

Түүгээрээ л явчих байсан юм. Тэгэхгүй одоо ингээд нэг жижигхэн бас дахиад л нэг улс төр. Нөгөө хасна, хэмнэнэ гээд байсан улсууд яг түүн дээр тулаад ирэхээр одоо хасуулахгүй уралдаан яваад эхлэхээр тэрнээсээ зугтаагаад хойшоо бүгдээрээ ингээд суучих юм. Үгүй.

Тэр дээр Засгийн газрын үндэслэн гэж явбал бид тооцоо судалгаа хийгээд л ингээд л хүргүүлье л дээ.

Тэгээд л өнөөдөр батлах гэж байсан тэр дэгээрээ л явчихна биз. Улсын Их Хурлын гишүүдэд ямар ч гал гарахгүй. Одоо тэр нэг баахан улс төр хийсэн улсууд тэгээд л улс төр хийгээд л амжилттай болоод л дууссан. Хасна танадаг тэр ийм баатрууд болсон.

Тэгэхээр уг нь өнөөдөр явсан тэр дэг чинь Ч.Лодойсамбуу гишүүний ахалж гаргаж ирсэн төсөл боломжийн л төсөл байлаа шүү дээ. Би өнөөдөр хэлсэн. Ч.Лодойсамбуу гишүүн тэрийгээ уг нь нэг сайхан хамгаалаад гарчихвал уг нь зүгээр байсан юм.

Тэгэхгүй бол одоо энэ буцаад бүр дахиад бүр ямар ч гарц байхгүй ийм мухардалд орно шүү. Дахиж шинээр өргөн барьдаг тийм дэг байхгүй.

Ц.Даваасүрэн: Нэгэнт Их Хурал батлаад дэмжээгүй юм чинь одоо тэгээд хойшоо ухарч яриад яах вэ.

Нөгөө талаараа одоо ингээд нэгэнт төсвийн тэнцлийг сайжруулна гэсэн учраас наадах чинь зардлуудыг чинь хасах асуудал, дахин төлөвлөх асуудал үүсчхэж байгаа учраас Их Хурлын гишүүдийн дийлэнх бас нэлээн олон гишүүн энэ төлөвлөлттэй холбогдож байна.

Төлөвлөх бүрэн эрх бол Засгийн газарт байна гэж үзсэн учраас энэ хуулийн төсөл дэмжигдээгүй байх гэж бодож байна.

Хугацааны талаар та санал хэлэх боломжгүй байгаад байна уу? Ирэх дөрөв дэхэд.

Б.Жавхлан: Одоо энэ чинь хоригийн хүрээнд засвар хийх бол одоо шинээр өргөн барих болчихоор энэ чинь бүхэлд нь энэ чинь бүр ингээд үзэл баримтлалаасаа эхлээд бүх юм явна шүү дээ.

Одоо үүнтэй чинь холбоотой төсвийн хүрээний мэдэгдлүүд өөрчлөгдөх нь ойлгомжтой. Дээрээс нь жилийн хөгжлийн төлөвлөгөөнүүд өөрчлөгдөнө. Зорилтот түвшин, энэ төлөвлөгөө, хөтөлбөр дээр ч өөрчлөлтүүд орно.

Тэгэхээр маш их олон хууль зэрэг өргөн барих шаардлагатай болж ирж байгаа. Тийм.

Тэгэхээр ирэх долоо хоногт эд нар яагаад ч амжихгүй байхгүй юу.

Тэгэхээр энэ чинь төсөв батлах хугацаа чинь өөрөө ингээд 4 хэлэлцүүлэг рүү буцчихаж байгаа гэсэн үг. Шинээр өргөн барихаар.

Тэгээд батлагдлаа гэхэд дараа нь соёрхон батлах хугацаа, дараа нь ингээд Ерөнхийлөгчийн дахиад хугацаа хүлээнэ гээд. Ингээд 12 сард үндсэндээ багтахгүй болж байна л гэсэн үг.

Тэгээд ирэх жил бид ер нь төсөвгүй он гаргах юм уу. Төсвөө ямар горимоор яаж явах нь тодорхойгүй болж байна л гэсэн үг.

Ц.Даваасүрэн: Х.Тэмүүжин гишүүн. Та нар тогтоол дээр тавих хугацаан дээр бас саналаа хэлээрэй.

Х.Тэмүүжин: Би Сангийн сайдаас асуух гээд байсан юм. Хугацаа гээд.

Ирэх долоо хоногийн тав дахь гэхэд өргөн барих боломж байгаа юм уу, үгүй юм уу гээд. Бараг байхгүй гэж байгаа юм бол төсөл дээр ер нь 14 хоног юм уу, 10 хоногоор нь хугацаа тавьж өгөөд Засгийн газарт чиглэл өгсөн нь дээр байх. Нэг.

Өргөн барихтай холбоотой асуудал бол Засгийн газрын асуудал.

Өргөн барьж байгаа хуулиа хүлээж аваад хэлэлцэх асуудал бол Улсын Их Хурлын асуудал.

Тэгээд Улсын Их Хурал бол яах аргагүй яг энэ хоригийг хүлээж аваад буцааж байгаатай холбоотой нэг уулзвар дэгийн нэг жижигхэн өөрчлөлтийг хурдан хийх хэрэгтэй байх. Сая бол буцаахгүйгээр үргэлжлүүлээд хэлэлцэх дэг чинь уначихлаа шүү дээ.

Тэгэхээр одоо буцаасантай холбоотой, хүчингүй болгоод шинээр өргөн барьж байгаатай холбоотой яг нэг уулзвар нэг, хоёр заалт л хэрэгтэй болох байх.

Тэгээд л бусад нь бол үндсэн дэгээрээ л явчихна шүү дээ. 98-аар байна шүү дээ.

Ц.Даваасүрэн: Б.Жавхлан гишүүн ээ, энэ дээр ямар нэгэн маргаан байхгүй.

90.8-аар хоригийг хүлээж авсан бол бүхэлд нь хүчингүй болгож болно гэж байгаа байхгүй юу.

Тэгээд тэр дагуу л явж байна шүү дээ.

Хоёр дахь заалт нь юу вэ гэвэл хэрвээ шаардлагатай гэж үзвэл нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, тогтоолын төслийг хэлэлцэнэ гэж байгаа юм. Нэмэлт, өөрчлөлт. Тодотгол байгаа байхгүй юу.

Тийм учраас бид Их Хурал дээрээ тодотгоод явчхаж болохгүй болчхоод байгаа байхгүй юу даа.

Тийм учраас төлөвлөлт рүү чинь орчих гээд байна гэдэг агуулгаар манай хуульч гишүүд нэлээн энэ дээр хатуухан байр суурь барьсан учраас өнөөдөр бид одоо тэр хоёр дахь заалтын дагуу “нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн” гэж ойлгогдоод “буцааж байна” гэж.

Угаасаа хүчингүй болчихсон шүү дээ. Хоригоо хүлээж аваад. Хоригоо хүлээж аваад хүчингүй болчихсон байхгүй юу.

Д.Батлут гишүүн. Д.Батлут гишүүний санаа давхацсан байна. Д.Ганбат гишүүн.

Д.Ганбат: Хоёр Байнгын хороо нийлж хуралдаад их зөв шийдвэр гаргаад байгаа юм гэж ойлгож байна.

Эхнээс нь хэлэлцээд явах нь зөв байх. Эхнээс нь хэлэлцээд явъя гээд санал өгсөн байгаа. Энэ бүх хуулийг дэмжсэн байгаа шүү. Намайг дэмжсэнээр тооцчихоорой.

Нөгөө талаар одоо нэг юм байна шүү дээ. Нэг юм нь юу гэхээр энэ орон нутаг гарцаагүй зардлууд байгаа. Гарах ёстой. Бид угаасаа энэ ондоо амжихгүй болчихлоо шүү дээ.

Тэгэхээр удахгүй шинэ жил гээд байна. Тэгэхээр энэ бүх юмаа амжихгүй. Тэр болтол 01 сарын 01-нээс эхний нэг, хоёр сар мэдээж хэрэг юу явах байх тэр орон нутаг нь хэвийн үйл ажиллагаагаа явуулах гарцаагүй зардлууд байгаа шүү дээ.

Хүн болгонд хэрэгтэй цалин мөнгө, бензин тос. Одоо цагдаа нь үйл ажиллагаагаа явуулах, эмч нь хэвийн үйл ажиллагаа явуулах. Энэ зардлуудыг нь бол яг байх ёстойгоор нь баталж өгчхөөд нөгөө юмыг нь бол эхнээс нь хэлэлцээд.

Ер нь Ерөнхийлөгчийн тавьсан энэ хоригийг бол бид боломж гэж харах хэрэгтэй л дээ.

Бүх хуулиудыг одоо энд нийцүүлээд шинэчлээд явах хэрэгтэй. Тэр эрх нь Улсын Их Хуралд байгаа.

Уг нь бол яг энэ Засгийн газар чинь төсвөө оруулж ирээд, энэ төсвийг нь 80 хувиар буцаачхаж байгаа нөхцөлд Засгийн газрын асуудлыг л ярих л ёстой байхгүй юу. Итгэл үзүүлж байна уу, үгүй юу гээдб

Одоо тэр нь өөр хэрэг байх. Аль болохоор ажил төрлөө хийхийн тулд түрүүн яриад байхад бол чуулган дээр Ч.Лодойсамбуу гишүүний оруулж ирж байгаа тэр хууль чинь нэг бол Их Хурал нь байхгүй юм шиг болчих гээд байдаг, нэг болохоор

Засгийн газар нь байхгүй юм шиг болчих гээд байдаг тийм л болчихсон байсан шүү дээ.

Одоо яг байр байрандаа ороод хэвийн үйл ажиллагаа явуулах боломжтой болчихлоо.

Тэгэхээр цаг хугацааны хувьд ахиухан тавиад өгчих өө. Тэр юмаа сайн боловсруулаад ороод ир ээ. Энэ Засгийн газарт нь ч өөрт нь тэгээд бас анхааруулга өгчих. Наад тогтоол юм хумдаа.

Ц.Даваасүрэн: Тийм. Д.Ганбат гишүүний хэлээд байгаа яах вэ ингээд хууль ондоо багтахгүй бол яах вэ гэдэг зохицуулалт төсвийн хуульд хийгдчихсэн байгаа. Цалингийн доод хэмжээгээр цалинг олгоод явна гэсэн заалтууд байж байгаа.

Ер нь Д.Ганбат гишүүний хэлж байгаа үнэн байхгүй юу. Бид энэ өргөн барьсан төсвийн хуулийг муу хууль гэж үзсэн юм бол, зардал өндөр байна гэж үзсэн юм бол бид эхний хэлэлцүүлэг дээрээ буцаах байсан байхгүй юу. Тогтвортой байдлын хуульд нийцэхгүй байна.

Төсвийн тухай хууль, бусад хууль тогтоомжтой нийцэхгүй. Буцаагаагүйгээс болоод өнөөдөр өөрсдөө бид Их Хурал маш хүнд байдалд орж байгаа юм. Ямар хүнд байдал гэвэл 01 сарын 01-нээс төсөв хэрэгжих ёстой байдаг.

Бусад улс оронд хэрвээ төсөв батлагдахгүй бол Засгийн газар, аль эсвэл Их Хурлын итгэл үзүүлэх асуудал яригддаг учраас.

Ер нь бид цаашдаа Их Хурал маш хариуцлагатай анхааралтай хандаж яг цагийн юмыг цагт нь шийдвэр гаргахгүй бол өнгөрсөн борооны хойноос цув нөмрөхөөр бол иймэрхүү байдал руу бид орчхож байгаа юм гэдгийг одоо хэлье.

Б.Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Энэ асуулт санал цуг явж болно. Тийм ээ.

Ингэж хэлмээр байна. Өмнөх гишүүдийн саналыг сонсоод давхацсан эсэхээ хасчихъя.

Тэгээд миний хувьд бол ингэж бодож байна. Одоо ухарч бодохоор нэгдүгээр хэлэлцүүлгийн дараа буцаах байсан л гэнэ. Ингээд нөгөө хайран цаг хугацааны асуудлууд яригдаад байна.

Зүгээр одоо үүнээс хойш яаж. Түрүүн бас нөгөө Ц.Даваасүрэн гишүүн таныг ярихаар миний анхаарал сарниад байна гэдэг шиг. Тийм.

Би бол ийм саналтай байгаа байхгүй юу. Ёс зүйн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо шинэ дэг гаргаж ирье гээд явсан. Сая Их Хурал дээр уначихдагийг бол би хариуцлагагүй байдал гэж хараад байгаа юм. Нэгэнт өмнө нь алдаатай оноотой ингээд цаг хугацаа алдчихсан.

Тэгээд хоёр Байнгын хороо ороод. Яагаад тэр хоёрыг хуралдуулсан бэ гэхээр өмнөх чуулган дээр Их Хурлын дэгийн тухай хуулийн 90.8.99. Тэрийг хараад тусгай дэг хэрэгтэй юм байна гэж ярьсан. Тэгэнгүүт Улсын Их Хурлын тухай хуулийг харахаар 36.1.2 дээр байна уу. Төсвийн тухай хууль чинь өөрөө онцгой хууль учраас гээд явсан.

Тэгээд эргээд Дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлээ харж байгаад энэ хоёр хороо чинь хуралдаад ажлын хэсэг байгуулсан биз дээ.

Тэгээд тэр дээрээсээ дэг гаргаж ирээд хэлэлцэхэд унагаачхаж байгаа нь би бол дахиад хайран цаг хугацаа. Цаглаварын хувьд бид үнэхээрийн жоохон хариуцлагагүй хандаж байна л гэж хэлмээр байна.

Тэгээд одоо энэ орон нутгийн хэмжээнд ч бай, энээ тэрээ замбараагүй байдал үүсгэхгүйн тулд бид Ерөнхийлөгчийн хориг тавигдахаас бараг өмнө шахуу энэ төсөв хасагдах шаардлага үүсчихсэн гэдгийг манай Төсвийн ерөнхий л захирагчид болон ерөнхийлөн захирагчид буюу сайд нар гэсэн үг. Тийм ээ.

Тэгээд нэмээд Сангийн яамныхан маань мэдчихсэн. Орон даяар, нийгэмд олон нийт ер нь гишүүд ямар зарцуулалт зардлуудыг хасаасай гэж хүсэж байгаагаа 4 удаагийн шатны хэлэлцүүлэгт хэлчихсэн юм чинь бэлтгэл ажил явагдчихсан байх гэж бодож байна. Тийм төсөөлөл байна.

Тэгэхээр харьцангуй 14 биш, арай богино хугацаанд энэ дээр ажиллаач ээ гэж гишүүний хувьд санал тавимаар байгаа юм. Багцлаад ингээд хэлье дээ. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Тийм. Энэ төсвийн жил эхлэхэд хэрвээ төсөв батлагдаагүй байвал яах вэ гэдгийг Төсвийн тухай хуулийн 41.4-өөр зохицуулчихсан байгаа юм.

Төсвийн жил эхлэх төсөв батлагдаагүй байх нөхцөл байдал үүсвэл төсөв батлагдах хүртэл төсвийн санхүүжилтийн түр горимыг энэ хуулийн 41.6-д заасны дагуу эрх бүхий этгээд тогтоож төсвийн зарлагыг дараах байдлаар санхүүжүүлнэ гээд.

Төсвийн байгууллагад ажилтны цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийг доод хэмжээгээр нь, Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгийг өмнөх түвшинд нь, батлан хамгаалах, эрүүл мэнд, боловсрол, хил хамгаалах, үндэсний

аюулгүй байдлыг хангах, шүүх, прокурорын байгууллага, цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдал, татвар, гааль болон бусад төрийн захиргааны байгууллагын үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг өмнөх түвшинд нь гээд заагаад өгчихсөн.

Тийм учраас мөн хэрвээ зээлийн хүүтэй холбогдолтой үндсэн хүүгийн төлбөрийг уг зээлийн гэрээнд заасан хугацаа төлбөрийн хэмжээгээр нь, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны урсгал төсвийг тэдгээрийн өмнөх оны урсгал төсвийн 50 хувиар гээд зохицуулалт хийгээд өгчихсөн байгаа юм. Өмнө нь ковидын үед одоо бас ийм нөхцөл байдал үүссэн учраас.

Тэгэхээр зохицуулалт байна.

Хугацааны хувьд гишүүд янз бүрийн санал хэллээ.

Тэгэхээр энэ санал дээр хэдүүлээ тогтох хэрэгтэй байна. Ямар хугацаа өгөх вэ гэдэг асуудал.

Х.Булгантуяа гишүүний микрофоныг өгье.

Х.Булгантуяа: Засгийн газраас өргөн барих хугацааны асуудлыг ярьж байна.

Тэгээд хугацааны хувьд өнөөдрөөс 11 хоног. Тэгээд ер нь бид чинь угаасаа сая төсвийг батлахдаа Засгийн газарт чиглэл өгчихсөн байсан. 12 сарын дотор төсвийн тодотголыг өргөн барь гэдэг чиглэл өгсөн байсан учраас Сангийн яам аль хэдийн ажиллаж байгаа.

Б.Мөнхсоёл гишүүн түрүүн хэлж байсан. Хэд хэдэн хувилбаруудыг ер нь гаргачихсан ажиллаж байгаа юм байна лээ.

Тэгэхээр аль болохоор шахаж өгөхгүй бол нэгдүгээрт аудит орох ёстой.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө хориг хүлээж авсантай холбоотой шинэ төсөлтэйгөө танилцах ёстой.

Ингээд бид шинэ жилдээ яг баяр ёслолын дундуур төсөв хэлэлцээд байх бас жоохон зохимжгүй байх байх.

Тэгэхээр аль болохоор жоохон наашаа шахъя гээд 10-ны дотор өргөн барих гэдэг.

Араас нь энэ чинь орон нутаг. Эхлээд аймгууд, нийслэл. Тэгээд дараа нь сумдууд орох ёстой шүү дээ.

Тэгэхээр сум бараг 31 төсвөө батлах юм уу хаашаа юм, болох гээд байх шиг байна. Тийм.

Ц.Даваасүрэн: Тэгвэл Х.Булгантуяа гишүүний гаргасан төсвийг 12 сарын 10-ны дотор өргөн мэдүүлэх гэсэн горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 29 гишүүн оролцож, 17 гишүүн дэмжиж, 58.6 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Ж.Батжаргал гишүүнийг дэмжсэнээр авъя.

Ингээд “Хууль хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын төслийн төслийг хэлэлцэж дууслаа.

Чуулганы хуралдаанд Х.Ганхуяг гишүүн танилцуулчихъя.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Гишүүд ээ, нэг санал хураалт хийх юм байна. Байж байгаарай.

“Хуулийг хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

29 гишүүн санал хураалтад оролцож, 18 гишүүн дэмжиж, 62.1 хувиар тогтоолын төслийг хэлэлцэх нь дэмжигдлээ.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан.

Ж.Батжаргал гишүүнийг тогтоолын төслийг дэмжсэн.

Санал, дүгнэлтийг Х.Ганхуяг гишүүн танилцуулна.

Л.Соронзонболд гишүүн бас дэмжсэн байна. Тийм үү. Протоколд авъя. Өнөөдрийн хуралдаан дууслаа. Баярлалаа гишүүд ээ.

Хамтарсан хуралдаан 47 минут үргэлжилж, 13 цаг 31 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД